

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Би та бүхэнтэй маргааш болох Намрын Баярын үеэр уулзана гэж найдаж байна. Энэ арга хэмжээний талаарх мэдээлэлтэй та бүхэн танилцаарай.

Ирэх хэдэн долоо хоногийн хугацаанд би зарим эцэг эхчүүдтэй уулзаж хүүхдийн тань сургалтын талаар санал солилцох бодолтой байгаа. Сургуулийн Захирлын хувьд энэ хичээлийн жилд тавих зорилтоо тодорхойлохын тулд ОУДС-ийнхаа талаар сайтар судлах төлөвлөгөөтэй байгаа талаараа би Мэдээнд дурдаж байсан. Олон улсын боловсрол олгодог байгууллагынх нь хувьд эцэг эхчүүд манай ОУДС-ийн талаар ямар бодолтой байдаг талаар та бүхний заримтай нь уулзаж ярилцах болно. Хэрвээ та бүхэн надтай 45 минут уулзаж ярилцах цаг завтай бөгөөд санал солилцох бодолтой байгаа бол уулзалтын цаг, өдрийг товлохоор миний туслах Энхээ рүү administration@isumongolia.edu.mn хаягаар е-мэйл бичээрэй. Бидний санал солилцох сэдэвтэй холбоотой асуултуудыг бид та бүхэнд илгээх болно.

10 сард ирж Магадлан Итгэмжлэлийн Шалгалт хийх багийхан эцэг эхчүүдтэй уулзаж санал солилцох болно. (Магадлан Итгэмжлэлийн багийн айлчлалын талаар багш Margriet Faber-ийн бичсэн мэдээллийг уншина уу)

Энэ айлчлалын гол зорилго нь сургууль ажлаа хэрхэн сайжруулсан бэ гэдгийг тодорхойлох явдал юм. Айлчлалын баг олон улсын сургуулиудад мөрддөг стандартыг манай ОУДС хэрхэн хэрэгжүүлж ямар амжилт ололт гаргасаныг болон цаашид юун дээр анхаарч сайжруулах талаар дүгнэлт хийж тайлан бичиж зөвлөмж гаргана. Энэ үйл явцад эцэг эхчүүд та бүхэн оролцох нь үнэлж баршгүй хувь нэмэр байдаг.

Ажил сайжруулах талаар дурдахад өглөөдөө машины зогсоол дээр жолооч нар машинуудаа зөв байрлуулж сурагчдыг буулгаж аюулгүй байдлыг хангах тал дээр ахиц гарч байна. Өглөөд бид машины зогсоол дээр конторын ажилтнуудаа зогсоож хөдөлгөөний зохицуулалт хийлгэж байгаа бөгөөд тэд жолооч нарт машинаа зогсоолд бүрэн зогсоосны дараа сурагчдыг буулгаж байх талаар анхааруулж байгаа.

Өглөөдөө нэлээд олон сурагчид хоцорч ирж байгааг бид ажигласан. Энэ байдал хичээл цагтаа эхлэхэд нөлөөлж байна. Олимпийн гудамжны замын хөдөлгөөн ялангуяа Махатма Гандийн гудамжтай нийлдэг уулзварын хөдөлгөөн улам түгжирч байна. Замын хөдөлгөөний түгжрэл буурахгүй байгаа энэ үед өглөөдөө эртхэн гэрээсээ гарч хүүхдээ цагт нь сургуульд нь хүргэж ирж байхыг би та бүхнээс хүсье.

Та бүхэн маргааш Намрын Баярт ирж цагийг сайхан өнгөрүүлээрэй. Бямба гарагт уулзацгаая.

Захирал Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

9 сарын 17-ны Бямба гараг

ОУДС-ийн Намрын Баяр **11:00-14:00**

9 сарын 23-ны Баасан гараг

Фото Зургийн өдөр

10 сарын 9-14

Магадлан Итгэмжлэлийн багийн айлчлал

10 сарын 17-25

Сурагчдын Намрын Амралт

Монгол, Солонгос эцэг эхчүүдэд зориулсан уулзалт

Өчигдөр бид Монгол, Солонгос эцэг эхчүүдэд төрөлх хэл дээр нь ОУДС-ийн талаар мэдээлэл өгөх уулзалт зохион байгуулсан. Энэ уулзалтанд хүрэлцэн ирсэн эцэг эхчүүдээ баярлалаа. Эцэг эхчүүд энэ уулзалтын талаар өндөр сэтгэгдэлтэй байсан бөгөөд тэдний олон асуултанд хариулт өгсөн их хэрэгтэй уулзалт боллоо гэж дүгнэсэн.

Уулзалтыг надтай хамт удирдаж явуулсан Mr. Choi, Mrs. Hanselmann нарт болон мэдээллийн орчуулгыг хийж тусалсан Ms. Энхээ, багш Эрдэнэцэцэг нарт талархал илэрхийлье.

Дэд Захирал А. Туул

Магадлан Итгэмжлэлийн Багийн Айлчлал

Эрхэм Хүндэт Эцэг Эхчүүд ээ,

10 сарын 9-14-ны хооронд IBO/CIS/NEASC байгууллагуудын хамтарсан магадлан итгэмжлэлийн багийн гишүүд сургуулийн ажлыг шалгах аар айлчлан ирнэ. Энэ багийнхан багш нар, ажилчид, сурагчид, эцэг эхчүүдтэй уулзалт хийнэ.

10 сарын 10-ны Даваа гарагт 15:00-15:45-д энэ багийн гишүүдтэй анги бүрээс төлөөлж уулзах эцэг эхчүүд бидэнд хэрэгтэй байна. Хэрвээ та бүхэн энэ уулзалтанд оролцох хүсэлтэй бол өөрийн овог нэр, хүүхдийнхээ анги, холбоо барих утасны дугаараа бичиж Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann-д secondaryhead@isumongolia.edu.mn хаягаар e- мэйл явуулаарай.

Та бүхэнд баярлалаа.

Бага Сургуулийн Хөтөлбөрийн Зохицуулагч Margriet Faber

ОУДС-ийн Намрын Баяр

Бид жил бүрийн уламжлалт Намрын Баяраа энэ Бямба гарагт 11:00-14:00 цагийн хооронд хийх гэж байна. Энэ үеэр олон хөгжөөнт тоглоом, бусад сонирхолтой арга хэмжээнүүд зохиогдож гар урлал, бэлэг дурсгалын худалдаа явагдана. Мөн энэ үеэр Канадын “Red Sky” хамтлагийн бүжигчид өөрсдийн тоглолтоос сонирхуулна. Энэ хамтлаг өчигдөр Дуурь Бүжгийн Эрдмийн Театрт тоглолтоо хийсэн.

Манай багш сурагчид намрын баяртаа оролцохоор хүлээж байна. Эцэг эхчүүд та бүхэн бидэнд жигнэмэгийн худалдаа хийх, тоглоом тоглох билет зарах, мөн шагнал олгох ширээн дээр хуваарийн дагуу суух зэрэг ажлуудад нэрээ бичүүлж тусалж болно. Та бүхэн мөн жигнэсэн бүтээгдэхүүн авчирч жигнэмэгийн худалдаанд оролцож болно. Та бүхэн Elena-тай elenamarchenko@yahoo.co.uk; 95875839 дугаарын утсаар; Билэгтэй eebileg@gmail.com; 99055243 дугаарын утсаар тус тус холбогдоно уу.

Баярлалаа.

ОУДС-ийн Эцэг Эх Багш нарын Бүлэг (ЭББ)

ШИНЭ ЗАМ НЭЭГДЭНЭ

Эцэг Эхчүүд та бүхний анхааралд,
Манай сургуулийн хойд талаар тавигдсан 4 эгнээтэй шинэ зам маргааш 9 сарын 17-ны Бямба гарагт нээгдэнэ. Манай сургуулийн гадаах зам урдаасаа хойшоо чиглэлтэй (ОУДС-ийн гудамж) нэг урсгалтай хэвээрээ өөрчлөгдөхгүй бөгөөд одоо мөрдөж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зохицуулалтанд нөлөөлөхгүй.

Шинээр нээгдэх 4 эгнээтэй зам дээр “ОУДС-ийн Гудамж” руу зүүн эргэхгүй гэдгийг жолооч нарт анхааруулсан тэмдэг тавигдана. Гэхдээ шинэ тавигдсан замаар жолооч нар явж хэвштэл энэ байдал гарч болзошгүйг анхаарна уу.

ОУДС-д байнга ирдэг жолооч нар урьд нь ирж байсан замаараа л цаашид ирж байх болно. **Та бүхэн ОУДС-руу шинэ 4 эгнээтэй замаар орж ирэх боломжгүй.**

ОУДС-ийн гудамжаар урсгал сөрөн буруу чиглэлээр орж ирж болзошгүй жолооч нараас болгоомжлох хэрэгтэй.

Хэрвээ та бүхэнд асуух асуулт байвал administration@isumongolia.edu.mn хаягаар болон 70160010 дугаарын утсаар бидэнтэй холбогдоорой.

Захирал Robert Stearns

Сурлагын Түвшин Тогтоох Шалгуур Тест

3-10-р ангийн сурагчдын эцэг эхчүүдийн анхааралд,

Ирэх 2-3 долоо хоногт Сурлагын Түвшин тогтоох тестийг сурагчид өгөх болно. Өнгөрсөн жил бага сургуулийн сурагчид унших, тооны хичээлээр тест өгч шалгуулж байсан. Дунд сургуулийн сурагчид унших, хэлний хичээл, тоо, байгалийн шинжлэлийн хичээлүүдээр тест өгч шалгуулж байсан. Энэ жил бид дахин шалгалт авах бөгөөд бага сургуулийн сурагчид хэлний хичээлийн тестийг нэмж өгнө.

Сурлагын Түвшин Тогтоох тест нь цаг заадаггүй бөгөөд сурагчид өөрсдийн хэмжээнд тестний асуултанд хариулах боломжтой. Сурагчдын тестийн үр дүнг өмнөх тестийн үр дүнтэй харьцуулж тэдний сурлагын ахицыг тогтоох боломжтой. Энэ шалгуураар тухайн сурагчийн мэдлэгийн түвшинг тогтоосон дүнг бусад сурагчийнхтай хооронд нь харьцуулдаггүй гэдгийг ойлгох нь чухал.

Энэ тестийг зөвхөн ОУДС-ийн хэмжээнд хэрэглэдэг бөгөөд шалгалтын мэдээлэлд тулгуурлан тухайн багш сурагч тус бүрийнхээ сурах арга барил, чадварт нийцүүлэн хичээл заах аргаа сонгож сургалт явуулж сурагчдын сурах арга барилыг дээшлүүлэхэд тусалдаг.

Энэ тестэнд манай сурагчид зориуд бэлтгэх шаардлага байхгүй. Хэрвээ хүүхэд тань тестний талаар санаа зовсон байдалтай байвал тестний үр дүн тэдний сурлагын дүнд шууд нөлөө үзүүлэхгүй гэдгийг та бүхэн сайтар тайлбарлаж өгөөрэй. Сурагчдыг хоолоо сайн идэж, сайн унтаж амарч байгаа эсэхэд анхаарсанаар тестийг амжилттай өгөхөд нь та бүхэнд тэдэнд туслах боломжтой. Тэдний тархи сайн хооллож, сайн амарч байж сурагчид сурлагандаа амжилт гаргана. Хэрвээ та бүхэнд асуулт байвал надтай болон Бага Сургуулийн Эрхлэгч Richard Elya-тай холбоо бариарай.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Сурагчид маань одоо эхний бүлэг сэдвээ үзэж байгаа бөгөөд тэдний сонирхол мэдлэгийн хүрээ тэлж байгааг харахад таатай байна. Манай багш нар сурагчдад хамт олон орчин тойрноосоо суралцах олон боломжуудыг гаргаж өгч байгаа нь надад их сайхан санагдсан. 4, 5-р ангийн сурагчид хэд хэдэн зочдыг урьж судалж буй сэдвийн хүрээнд итгэл үнэмшил, эрхэмлэдэг зүйлс, шийдвэр гаргах талаар тэдэнтэй санал солилцлоо. 2-5-р ангийн сурагчид Хүнсний зах, Уран зургийн музей, Гандан хийд, Оросын Сүм зэрэг газруудаар хичээлийн холбогдолтой аялалуудыг зохион байгууллаа.

Эдгээр нөөц бололцоо, эх үүсвэрүүдийг бид “үндсэн нөөц бололцоо” гэж үздэг бөгөөд сурагчдыг бүх талаар хөгжүүлэх боловсрол эзэмшүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг юм. Сурагчдад ийм боломжуудыг олгож шинийг эрэлхийлж байдаг сайн багш нартай бид азтай хамт олон.

Улирал солигдож цаг агаар өөрчлөгдөж өглөөд хүйтэн болж байгаа тул та бүхэн сурагчдыг хичээлд нь дулаан хувцаслаж ирүүлээрэй.

Маргааш Намрын Баяр дээр уулзацгаая.

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya